БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: БНА-2026/148/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn
Баянхонгор хот
2026.02.25

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер: М.Алтантуяа
Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn
Аудитор: Н.Батчимэг
Утас: 91113253 Цахим хаяг: batchimegn@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
310 дугаар байр, Лувсандандзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement. bayankhongor@audit.gov.mn

2026.02.25 № 2/129

танай____________-ны № _____________ -т

БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНГОВЬ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ ДАРГА Ш.УРАНЧИМЭГ
ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна .

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

6426050361

/2026 он/1. бичиг хэрэг/тоот/2. а4-албан тоот.docx

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 1 удаа тодотгон улсын төсвөөс 2,301,032.8 мянга, орон нутгийн төсвөөс 186,667.4 мянга нийт 2,487,700.2 мянга, орон нутгийн төсвөөс 186,667.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудал**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Баянхонгор аймгийн Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 76 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг аймгийн Боловсролын газраас 83.3 хувиар үнэлсэн байна.

Баянхонгор аймгийн Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **346,547,805.83** | **285,643,607.85** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 243,075,424.02 | 203,531,975.91 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 243,075,424.02 | 203,531,975.91 |
| **3121** | **Төгрөг** | 243,075,424.02 | 203,531,975.91 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 243,075,424.02 | 203,531,975.91 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 103,472,381.81 | 82,111,631.94 |
| **351** | **Түүхий эд материал** | 27,382,207.20 | 25,396,450.94 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 27,382,207.20 | 25,396,450.94 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 20,700.00 | 19,300.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 76,069,474.61 | 56,695,881.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,115,340.00 | 430,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 71,656,734.61 | 55,622,881.00 |
| 35460 | Хүнсний материал | 00.00 | 1,500.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 3,297,400.00 | 641,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,155,247,313.91** | **2,088,097,449.91** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 2,155,247,313.91 | 2,088,097,449.91 |
| **392** | **Биет хөрөнгө** | 2,128,871,313.91 | 2,060,934,949.88 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,969,444,417.47 | 1,969,444,417.47 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -195,986,753.46 | -234,711,292.02 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 353,560,984.77 | 355,403,104.70 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -164,328,070.68 | -174,774,047.54 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 216,950,518.11 | 155,867,740.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -128,565,586.35 | -80,272,926.61 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 77,735,903.98 | 77,735,903.98 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -24,754,737.14 | -25,231,345.54 |
| 39217 | Ном | 24,814,637.21 | 17,473,395.44 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 26,376,000.00 | 27,162,500.03 |
| 39301 | Програм хангамж | 450,000.00 | 1,352,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -450,000.00 | -565,499.97 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 26,376,000.00 | 26,376,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,501,795,119.74** | **2,373,741,057.76** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **1,192,030.28** | **23,715,055.51** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 1,192,030.28 | 23,715,055.51 |
| **413** | **Өглөг** | 1,192,030.28 | 23,715,055.51 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 1,163,030.28 | 9,377.51 |
| **4136** | **Бусад өглөг** | 29,000.00 | 23,705,678.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 29,000.00 | 23,705,678.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,500,603,089.46** | **2,350,026,002.25** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 2,500,603,089.46 | 2,350,026,002.25 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 319,214,873.32 | 319,214,873.32 |

| | | | |
|---|---|---|---|
| 51101 | Өмч: - төрийн | 319,214,873.32 | 319,214,873.32 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,280,551,605.42 | 1,136,375,078.21 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,280,551,605.42 | 1,286,952,165.42 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -150,577,087.21 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 900,836,610.72 | 894,436,050.72 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,501,795,119.74** | **2,373,741,057.76** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,705,887,234.50** | **2,245,050,948.94** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **731,756,634.50** | **37,554,648.94** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 731,756,634.50 | 37,554,648.94 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,883,660.00 | 35,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,883,660.00 | 35,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,974,130,600.00** | **2,207,496,300.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,827,557,600.00 | 2,020,828,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,827,557,600.00 | 2,020,828,900.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 146,573,000.00 | 186,667,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 146,573,000.00 | 186,667,400.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,917,779,940.81** | **2,385,859,899.28** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,917,779,940.81** | **2,385,859,899.28** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,823,873,783.52 | 2,271,480,079.28 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,247,900,744.80 | 1,539,892,197.00 |
| 210101 | Үндсэн цалин | 752,845,078.80 | 925,355,446.00 |
| 210102 | Нэмэгдэл | 417,864,266.00 | 515,075,421.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 5,005,000.00 |
| 210104 | Урамшуулал | 77,191,400.00 | 94,456,330.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 156,914,206.99 | 191,343,432.14 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 106,930,417.57 | 130,432,405.18 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12,501,068.65 | 15,439,530.08 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,250,535.25 | 7,712,505.85 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 6,246,439.30 | 7,551,798.83 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 24,985,746.22 | 30,207,192.20 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 142,214,442.71 | 181,083,358.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,141,226.71 | 12,135,950.00 |
| 210302 | Түлш, халаалт | 131,753,216.00 | 168,167,408.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,320,000.00 | 780,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 13,485,290.00 | 41,211,677.20 |
| 210401 | Бичиг хэрэг | 9,279,990.00 | 14,266,940.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,176,300.00 | 2,206,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 29,000.00 | 00.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210408 | Бараа материал акталсны зардал | 00.00 | 24,738,737.20 |
| **2105** | **Нормативт зардал** | 83,477,000.00 | 112,911,900.00 |
| 210502 | Хоол, хүнс | 77,848,000.00 | 112,911,900.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 5,629,000.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,000,000.00 | 5,400,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,000,000.00 | 5,400,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 275,322.57 | 5,640,233.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 275,322.57 | 2,548,100.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 3,092,133.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 176,606,776.45 | 193,997,281.94 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 41,018,716.55 | 44,106,554.81 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 19,527,716.00 | 7,832,500.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 116,060,343.90 | 142,058,227.13 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 93,906,157.29 | 114,379,820.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 92,547,600.00 | 112,795,778.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 00.00 | 96,678.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 64,441,500.00 | 90,965,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 28,106,100.00 | 21,734,100.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 1,358,557.29 | 1,584,042.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,358,557.29 | 1,584,042.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **788,107,293.69** | **-140,808,950.34** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 00.00 | 9,768,136.87 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 00.00 | 9,768,136.87 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 00.00 | -9,768,136.87 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **788,107,293.69** | **-150,577,087.21** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,976,014,260.00** | **2,207,531,300.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,883,660.00** | **35,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,883,660.00 | 35,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 1,883,660.00 | 35,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,883,660.00 | 35,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,974,130,600.00** | **2,207,496,300.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,827,557,600.00 | 2,020,828,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,827,557,600.00 | 2,020,828,900.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 146,573,000.00 | 186,667,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 146,573,000.00 | 186,667,400.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,797,527,042.91** | **2,210,071,448.11** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,797,527,042.91** | **2,210,071,448.11** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,703,837,885.62** | **2,101,869,356.11** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,253,661,324.60 | 1,553,501,860.86 |
| 210101 | Үндсэн цалин | 798,526,255.80 | 906,063,673.56 |
| 210102 | Нэмэгдэл | 378,695,972.00 | 514,439,203.30 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 4,947,207.00 |
| 210104 | Урамшуулал | 76,439,096.80 | 128,051,777.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 151,153,627.19 | 178,887,421.05 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 102,299,742.31 | 119,886,597.05 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12,000,446.00 | 14,767,709.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,000,225.00 | 7,373,678.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 5,996,124.00 | 7,371,863.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 24,857,089.88 | 29,487,574.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 142,214,442.71 | 181,083,358.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,141,226.71 | 12,135,950.00 |
| 210302 | Түлш, халаалт | 131,753,216.00 | 168,167,408.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,320,000.00 | 780,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 77,646,570.00 | 118,993,050.00 |
| 210502 | Хоол, хүнс | 77,646,570.00 | 118,993,050.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,000,000.00 | 4,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,000,000.00 | 4,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 18,756,821.12 | 21,423,300.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 18,756,821.12 | 21,423,300.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 57,405,100.00 | 43,980,366.20 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 44,295,600.00 | 35,179,466.20 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 13,109,500.00 | 8,800,900.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **93,689,157.29** | **108,202,092.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 92,330,600.00 | 106,618,050.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 64,224,500.00 | 84,883,950.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 28,106,100.00 | 21,734,100.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 1,358,557.29 | 1,584,042.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,358,557.29 | 1,584,042.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **178,487,217.09** | **-2,540,148.11** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **53,991,019.00** | **37,003,300.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **53,991,019.00** | **37,003,300.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 53,991,019.00 | 37,003,300.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 53,991,019.00 | 37,003,300.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-53,991,019.00** | **-37,003,300.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 124,496,198.09 | -39,543,448.11 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 118,579,225.93 | 243,075,424.02 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 243,075,424.02 | 203,531,975.91 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **319,214,873.32** | **900,836,610.72** | **493,607,342.01** | **00.00** | **1,713,658,826.05** |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **319,214,873.32** | **900,836,610.72** | **493,607,342.01** | **00.00** | **1,713,658,826.05** |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 786,944,263.41 | 00.00 | 00.00 |
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **319,214,873.32** | **900,836,610.72** | **1,280,551,605.42** | **00.00** | **2,500,603,089.46** |
| D01 | **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **319,214,873.32** | **900,836,610.72** | **1,280,551,605.42** | **00.00** | **2,500,603,089.46** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 6,400,560.00 | 00.00 | 6,400,560.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **319,214,873.32** | **900,836,610.72** | **1,286,952,165.42** | **00.00** | **2,507,003,649.46** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -6,400,560.00 | 00.00 | 00.00 | -6,400,560.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -150,577,087.21 | 00.00 | -150,577,087.21 |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **319,214,873.32** | **894,436,050.72** | **1,136,375,078.21** | **00.00** | **2,350,026,002.25** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (улсын төсөв) (төгрөгөөр)

| Үзүүлэлт | Тайлант оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|
| | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 2,301,032,800.00 | 2,060,407,348.11 | 240,625,451.89 | 89.5 |
| **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 2,069,775,400.00 | 2,020,828,900.00 | 48,946,500.00 | 97.6 |
| Улсын төсвөөс санхүүжих | 2,069,775,400.00 | 2,020,828,900.00 | 48,946,500.00 | 97.6 |
| **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 231,257,400.00 | 39,578,448.11 | 191,678,951.89 | 17.1 |
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 35,000.00 | -35,000.00 | |
| Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 231,257,400.00 | 39,543,448.11 | 191,713,951.89 | 17.1 |
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 2,301,032,800.00 | 2,060,407,348.11 | 240,625,451.89 | 89.5 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | 2,301,032,800.00 | 2,060,407,348.11 | 240,625,451.89 | 89.5 |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,186,451,000.00 | 1,953,789,298.11 | 232,661,701.89 | 89.4 |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,723,294,600.00 | 1,553,501,860.86 | 169,792,739.14 | 90.1 |
| Үндсэн цалин | 1,055,091,300.00 | 906,063,673.56 | 149,027,626.44 | 85.9 |
| Нэмэгдэл | 596,730,900.00 | 514,439,203.30 | 82,291,696.70 | 86.2 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 4,947,207.00 | -4,947,207.00 | |
| Урамшуулал | 71,472,400.00 | 128,051,777.00 | -56,579,377.00 | 179.2 |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 215,842,900.00 | 178,887,421.05 | 36,955,478.95 | 82.9 |
| Тэтгэврийн даатгал | 146,773,100.00 | 119,886,597.05 | 26,886,502.95 | 81.7 |
| Тэтгэмжийн даатгал | 17,267,300.00 | 14,767,709.00 | 2,499,591.00 | 85.5 |
| ҮОМШӨ-ний даатгал | 8,633,800.00 | 7,373,678.00 | 1,260,122.00 | 85.4 |
| Ажилгүйдлийн даатгал | 8,633,800.00 | 7,371,863.00 | 1,261,937.00 | 85.4 |
| Эрүүл мэндийн даатгал | 34,534,900.00 | 29,487,574.00 | 5,047,326.00 | 85.4 |
| **Нормативт зардал** | 140,725,600.00 | 118,993,050.00 | 21,732,550.00 | 84.6 |
| Хоол, хүнс | 140,725,600.00 | 118,993,050.00 | 21,732,550.00 | 84.6 |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 29,703,300.00 | 29,175,000.00 | 528,300.00 | 98.2 |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 29,703,300.00 | 29,175,000.00 | 528,300.00 | 98.2 |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | 76,884,600.00 | 73,231,966.20 | 3,652,633.80 | 95.2 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 67,808,500.00 | 64,431,066.20 | 3,377,433.80 | 95.0 |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 9,076,100.00 | 8,800,900.00 | 275,200.00 | 97.0 |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 114,581,800.00 | 106,618,050.00 | 7,963,750.00 | 93.0 |
| **Бусад урсгал шилжүүлэг** | 114,581,800.00 | 106,618,050.00 | 7,963,750.00 | 93.0 |
| Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 92,847,700.00 | 84,883,950.00 | 7,963,750.00 | 91.4 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 21,734,100.00 | 21,734,100.00 | 0.00 | 100.0 |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 243,075,424.02 | | |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 203,531,975.91 | | |
| **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 49 | 49 | 0.00 | 100.0 |
| Удирдах ажилтан | 1 | 1 | 0.00 | 100.0 |
| Гүйцэтгэх ажилтан | 36 | 36 | 0.00 | 100.0 |
| Үйлчлэх ажилтан | 12 | 12 | 0.00 | 100.0 |

**Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (орон нутгийн төсөв)** (төгрөгөөр)

| Үзүүлэлт | Тайлант оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|
| | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 186,667,400.00 | 185,083,358.00 | 1,584,042.00 | 99.2 |
| **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 186,667,400.00 | 185,083,358.00 | 1,584,042.00 | 99.2 |
| Орон нутгийн төсвөөс санхүүжих | 186,667,400.00 | 185,083,358.00 | 1,584,042.00 | 99.2 |
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 186,667,400.00 | 185,083,358.00 | 3,388,076.00 | 99.2 |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | 186,667,400.00 | 185,083,358.00 | 3,388,076.00 | 99.2 |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 186,667,400.00 | 185,083,358.00 | 3,388,076.00 | 99.2 |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 182,667,400.00 | 181,083,358.00 | 1,584,042.00 | 99.1 |
| Гэрэл, цахилгаан | 13,500,000.00 | 12,135,950.00 | 1,364,050.00 | 89.9 |
| Түлш, халаалт | 168,167,400.00 | 168,167,408.00 | -8.00 | 100.0 |
| Цэвэр, бохир ус | 1,000,000.00 | 780,000.00 | 220,000.00 | 78.0 |
| **Эд хогшил, урсгал засварын зарда** | 4,000,000.00 | 4,000,000.00 | 00.00 | 100.0 |
| Урсгал засвар | 4,000,000.00 | 4,000,000.00 | 00.00 | 100.0 |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 | 00.00 | |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 | 00.00 | |

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үр дүнг нэгтгэв.

1. Бүтэц орон тоог Баянговь сумын ЕБС-ийн захирлын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар удирдах 1, гүйцэтгэх 34, үйлчлэх 15, нийт 50 албан хаагчийн орон тоог баталсан бөгөөд 1 албан хаагч жилийн чөлөө авч, 3 үйлчилгээний ажилтан ажлаас барсан ба орон тоог нөхөөгүй, тайлант оны эцэст 46 орон тоотой ажилласан байна.
2. Тус байгууллагын төсөвт хоолны зардал суугдаагүй бөгөөд цалингийн сангаас 38,490.0 мянган төгрөгийг зарцуулсан ба Боловсролын сайдын 2025 оны 02 сарын 11-ний өдрийн 1/554 дугаар албан бичгийг үндэслэн Захирлын 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн Б/16 дугаар тушаалаар 5.0 мянган төгрөгөөр тооцон олгосон байна.
3. Сургалт, семинарын 9,140.1 мянган төгрөгийн төсөв батлагдсан бөгөөд тайлант онд 5 төрлийн сургалтыг зохин байгуулж 5,848.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.
4. Тайлант онд “Санхүүгийн тооцоолох групп”-т санхүүгийн программын лицензийн төлбөрт 220.0 мянга, “Хас эрин орчил” ХХК-д мэдээний программын төлбөрт 160.0 мянга, “Дижитал эдү менежмент” ХХК-д “Эдүтэн” программын төлбөрт 6,090.0 мянга, Сурах бичгийн түрээсийн тогтолцоо-Эргэлтийн санд 345.6 мянга, “Ай и ди си” ХХК-д англи хэлний хичээл “Пирсон” программын төлбөрт 5,747.5 мянган төгрөгийг тус тус төлсөн байна.

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 230.0 мянган төгрөгийн 1 алдаа илэрснийг аудитын явцад залруулав. Үүнд:

1. Багш нарын сургалтын төлбөрт төлсөн төлбөрөөс буцаж орсон 230.0 мянган төгрөгийг санхүүгийн тайланд өөрийн үйл ажиллагааны орлогоор бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4 дэх “үнэн зөв байх”, санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 4,859.7 мянган төгрөгийн 5 зөрчил[1] илэрснээс, 2,786.9 мянган төгрөгийн 4 төлбөрийн акт тогтоож, 2,072.8 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүллээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлийн 4,859.7 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон 15,508.1 мянган төгрөгийн гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшнээс 10,648.4 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### 3.1 Төлбөрийн акт

3.1.1. Тайлант онд 1 багшид ээлжийн амралтыг 48 хоногоор олгохыг 52 хоногоор тооцож 289.6 мянган төгрөгийг амралтын олговорт илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.1-т "хөдөлмөрийн онцлогийг харгалзан бүх түвшний боловсролын сургалтын байгууллагын захирал, эрхлэгч болон бусад ажилтанд ажлын 15 өдөр, багш, багшийн туслах, дотуур байрны багш, нийгмийн ажилтан, хоол зүйч, сэтгэл зүйч, арга зүйч, сургалтын менежерт ажлын 33 өдрийн нэмэгдэл амралт олгох" гэсэн заалтыг зөрчиж, “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Амралтын олговорт илүү олгосон 289.6 мянган төгрөгийг захирал, нягтлан бодогч нараар төлүүлж төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.1.2. Улсын шалгалтын ажлын хэсэгт ажилласан 6 багшид 6 дугаар сард шийдвэргүйгээр 15 цагийн илүү цагийн хөлсөнд 1,327.3 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Засгийн газрын 2019 оны "Журам батлах тухай" 382 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын 3 дахь хэсгийн 1-т " Төрийн албан хаагч энэ журмын хавсралтаар баталсан “Нэмэгдэл хөлс тооцож

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

олгох хуудас”-ны дагуу илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласан үндэслэл, гүйцэтгэсэн ажлын гол агуулга, нэмэгдүүлсэн цалин хөлсний тооцоог нэгжийн даргаар хянуулж баталгаажуулсны үндсэн дээр байгууллагын дарга зөвшөөрөл олгосны дараа санхүүд хүргүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь:* Шийдвэргүй олгосон 1,327.3 мянган төгрөгийг дарга, нягтлан бодогч нараар төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.1.3. Захирлын 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн "Багш нарт гүйцэтгэлийн үнэлгээний урамшуулал олгох тухай" Б/101 дүгээр тушаалаар удирдах ажилтан, бусад албан хаагчид урамшууллыг олгохдоо 4.6 хувиар буюу 1,000.0 мянган төгрөгийг батлагдсан нормоос илүү олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2024 оны 25 дугаар тогтоолоор баталсан “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”-ын 3.4-т "Нэмэлт урамшууллын 65 хүртэлх хувийг албан хаагчдыг урамшуулахад зарцуулах бөгөөд урамшууллын хэмжээг ажлын гүйцэтгэл, чанар, үр дүнд үндэслэн доор дурдсан харьцааг баримтлан цэцэрлэг, сургуулийн зөвлөлөөр тус тус хэлэлцэж батална: 1. Удирдах ажилтан, бусад албан хаагч 40 хувь, 2. Багш нар 60 хувь” гэсэн заалтыг зөрчсөн.байна.

*Шийдвэрлэсэн нь:* Үр дүнгийн урамшуулалд нормоос хэтрүүлэн олгосон 1,000.0 мянган төгрөгийг холбогдох албан хаагчидтай тооцоо хийн төлүүлж төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.1.4. Тайлант онд 5 албан хаагчид хоолны хөнгөлөлтөд 170.0 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь:* Хоолны хөнгөлөлтөд илүү олгосон 170.0 мянган төгрөгийг холбогдох албан хаагчтай тооцоо хийн төлүүлж төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

**3.2 Албан шаардлага**

3.2.1. Захирлын 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн Б/11 дүгээр тушаалаар архив, бичиг хэргийн эрхлэгчид хүний нөөцийн цахим системийн ажлыг хавсруулан нэмэгдлийг 2025 оны 2,3,5,6 дугаар сард 40 хувиар тооцон нийт 2,072.8 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", “Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, мэдээлэл авах журам”-ыг зөрчсөн байна.

*<u>Шийдвэрлэсэн нь:</u>* Хууль журмаар тогтоогоогүй нэмэгдэл олгодог байдлыг таслан зогсоож, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалтыг хэрэгжүүлэн байгууллагын дарга хүний нөөцийн цахим системийн ажлыг гүйцэтгэх., зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

Аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг нотлох баримтын хамт төрийн аудитын байгууллагад төлбөрийн акт, албан шаардлагад заасан хугацаанд ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл** (мянган төгрөг)

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайланд орлогыг буруу тусган бүртгэсэн | 1 | 230.0 | - | - | 1 | 230.0 | 1 | 230.0 | - | - |
| **Дүн** | **1** | **230.0** | **-** | **-** | **1** | **230.0** | **1** | **230.0** | **-** | **-** |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл** (мянган төгрөг)

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцох албан шаардлага | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 |
| Тайлант онд 1 багшид ээлжийн амралтыг 48 хоногоор олгохыг 52 хоногоор тооцож 289.6 мянган төгрөгийг амралтын олговорт илүү олгосон байна. | 1 | 289.6 | 1 | 289.6 | - | - | - | - | | |
| Улсын шалгалтын ажлын хэсэгт ажилласан 6 багшид 6 дугаар сард шийдвэргүйгээр 15 цагийн илүү цагийн хөлсөнд 1,327.3 мянган төгрөгийг олгосон байна. | 1 | 1,327.3 | 1 | 1,327.3 | - | - | - | - | - | - |
| Захирлын 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн "Багш нарт гүйцэтгэлийн үнэлгээний урамшуулал олгох тухай" Б/101 дүгээр тушаалаар удирдах ажилтан, бусад албан хаагчид урамшууллыг олгохдоо 4.6 хувиар буюу 1,000.0 мянган төгрөгийг батлагдсан нормоос илүү олгосон байна. | 1 | 1,000.0 | 1 | 1,000.0 | - | - | - | - | - | - |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Тайлант онд 5 албан хаагчид хоолны мөнгөнд 170.0 мянган төгрөгийг илүү олгосон байна. | 1 | 170.0 | 1 | 170.0 | - | - | - | - | - | - |
| Захирлын 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн Б/11 дүгээр тушаалаар архив, бичиг хэргийн эрхлэгчид хүний нөөцийн цахим системийн ажлыг хавсруулан нэмэгдлийг 2025 оны 2,3,5,6 дугаар сард 40 хувиар тооцон нийт 2,072.8 мянган төгрөгийг олгосон байна. | 1 | 2,072.8 | - | - | 1 | 2,072.8 | - | - | - | - |
| **Дүн** | **5** | **4,859.7** | **4** | **2,786.9** | **1** | **2,072.8** | **-** | **-** | **-** | **-** |

-----------оОо-----------